



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/67

Чингис хот

Мэргэжлийн боловсрол, сургалтын
орон нутаг дахь салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 29.1.5-ын "а", Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн 2010 оны 07 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дүрэм"-ийг хэрэгжүүлэх зорилгоор "Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга	Засаг даргын орлогч
Дэд дарга	Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
Нарийн бичгийн дарга	Хэнтий аймгад дахь Политехник коллежийн захирал
Гишүүд	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
	Бор-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга
	Бор-Өндөр суман дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал
	Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
	Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын Тэргүүн
	Аймгийн барилгачдын холбооны тэргүүн
	Уулын баяжуулах "Бор-Өндөр" үйлдвэрийн захирал

2.

“Хэнтий-Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал

2. Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/122 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ